

**Аймгийн удирдах ажилтнуудын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн  
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2023.12.08

| №                       | Үүрэг даалгавар   | Биелэлт  | Хэрэгжилтийн хувь |
|-------------------------|---|--|-------------------|
| 1                       | Томуу, томуу төст өвчний улирал эхлэж байгаатай холбогдуулан салбарын болон бусад байгууллагуудтай хамтарч ажиллах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх | Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, аймгийн хэмжээнд 1780 вакцины тун ирснээс 1698 иргэн хамрагдан 95.4 хувьтай байна.<br>Үүнээс:<br>Сүмбэр сум- 1181 иргэн<br>Шивээговь сум- 349 иргэн<br>Баянтал- 168 иргэн   | 95.4 хувь         |
| 2                       | "Нэг өрх-Нэг ажлын байр" арга хэмжээний хүрээнд байгууллагууд өөрсдийн хариуцсан өрхийн иргэдийг эрт илрүүлэгт хамруулах ажлыг зохион байгуулах           | "Нэг өрх-Нэг ажлын байр" арга хэмжээний хүрээнд 17 байгууллага 52 иргэнийг эрт илрүүлэгт хамруулах ажлыг эхлүүлэн 12 дугаар сарын 08-ны өдөр 3 байгууллага (Сүмбэр сумын ЗДТГ,ГБХЗХГ,ХХҮГ) 10 иргэнийг үзлэгт хамруулсан. Үлдсэн иргэдийг 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хуваарийн даруу үзлэгт оруулахаар төлөвлөсөн.  | 30 хувь           |
| 3                       | Шатахуун түгээх байгууллагуудад чиглэл өгч уялдаа холбоотой ажиллах   | Шатахуун түгээх станцын дарга, Онцгой байдлын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар хамтарсан 3 удаагийн уулзалт зохион байгуулж, шатахуун түлшний хомсдолд анхаарч хамтран ажиллах чиглэлээр санал солилцож, шатахууныг 10 литрээс дээш хэмжээтэй олгож байхаар шийдвэрлэсэн.<br>Өнөөдрийн байдлаар "Шунхлай ХХК", "Сод Монгол Групп" 1.5-2 тонн шатахууны нөөцтэй, "Тэс Петролиум ХХК", "Петровис ХХК" 3 тонн шатахууны нөөцтэй байна. Нөөцдөө тааруулж өдрийн олгох хэмжээг тогтоож байна. | 70 хувь           |
| <b>Дундаж хэрэгжилт</b> |   |  | <b>65.1</b>       |

**Хянасан:** ХШҮ-ний хэлтсийн дарга:  
**Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:**  
ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн

М.АНХБАЯР  
Б.МӨНХЗАЯА

